



ZASAG CHANDMANI
MINES LLC

ЗАСАГЧАНДМАНЬ МАЙНЗ ХХК

**ЗАСАГЧАНДМАНЬ МАЙНЗ ХХК-ИЙН ЧАНДМАНЬ
УУЛЫН ТӨМӨР (ЗЭС, АЛТ)-ЫН ХҮДРИЙН ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ
ҮЙЛДВЭР**

**2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

(Дорноговь аймаг, Дэлгэрэх сум)

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015594

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА	1-1
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг	1-1
1.3 ТӨСЛИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	1-2
1.4 ОЛБОРЛОЛТЫН ТЕХНОЛОГИ	1-3
1.4.1 Ордын уул-техникийн нөхцөл	1-3
1.4.2 Геотехникийн судалгаа	1-3
1.4.3 Ил уурхайн оновчлол	1-4
1.5 Баяжуулах технологи	1-6
1.5.1 Хүдэр хүлээн авах, бутлалт	1-6
1.5.2 Хуурай баяжуулалт	1-6
1.5.3 Нойтон баяжуулалт	1-6
1.5.4 Бүтээгдэхүүн гаргалт	1-7
1.5.5 Усны эргэлтийн систем	1-7
1.6 ДЭД БҮТЭЦ	1-7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2-1
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3-1
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1
3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1
3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-1
3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-2
3.5 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-2
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-1
4.1 ГОЛ ЗОРИЛТ	4-1
4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	4-1
4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-1
4.4 НОГООН БАЙГУУЛАМЖ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-7
4.5 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-8
4.6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-8
4.7 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-8
4.8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-8
4.9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-11
4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	4-14
4.11 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	a
4.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	a

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт	1-2
Хүснэгт 1-2. Зөвлөмж болгосон ил уурхайн хажуугийн өнцөг	1-4
Хүснэгт 1-3. Хуурай баяжуулах үйлдвэрийн үзүүлэлтүүд	1-4
Хүснэгт 1-4. Нойтон баяжуулах үйлдвэрийн үзүүлэлтүүд	1-5
Хүснэгт 4-1. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	4-1
Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4-3
Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө	4-7
Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4-10
Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4-12
Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4-15
Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	a
Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	b

Зургийн жагсаалт



Зураг 1-1. Чандмань Уул ордын байршил	1-1
Зураг 1-2. Төслийн талбайн харагдах байдал.....	1-2
Зураг 1-3. Оновчтойгоор тодорхойлсон уурхайн хүрээ	1-5
Зураг 4-1. Ногоон байгууламжийн төлөвлөлтийн зураг	4-7
Зураг 4-2. Орчны хяналт шинжилгээний цэгүүд	4-14



ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Засагчандмань майнз ХХК-ийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОУАӨЯ-ны 2026.02.04-ны өдрийн 11/742 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2026 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд 2026 оны БОМТ нь 2026 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн эхний жилийн БОМТ юм.

БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА


1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> • Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Засагчандмань майнз ХХК • Улсын бүртгэлийн дугаар: 9011238027 • Регистрийн дугаар: 5382432 • Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-42, Капитал центр, 1401 тоот • Утас: +976 80088120 • Цахим шуудан: zasagchand@gmail.com, zasagoperation@gmail.com

1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг

Төслийн байршил нь Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Цагаан Хад 1-р багийн нутаг дэвсгэрт Чандмань нэртэй MV-015594 тоот 571.03 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршино. Тус төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 560 км, Сайншанд хотоос 116 км, Дэлгэрэх сумаас баруун урд зүгт 12 км зайтай. Мөн төмөр замын ачиж буулгах Улаан-Уулын өртөөнөөс зүүн тийш 120 км-т оршино. Төслийн талбайн тусгай зөвшөөрлийн талбайн байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Чандмань Уул ордын байршил



Зураг 1-2. Төслийн талбайн харагдах байдал

1.3 ТӨСЛИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төслийн үндсэн үзүүлэлтүүд болох үйлдвэрлэлийн нөөц, ил уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтэц, борлуулалтын орлого, үйл ажиллагааны нийт зардал, төслийн үнэ цэнэ (NPV) зэргийг нэгтгэж ТЭЗҮ-д тусгаснаар дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Ерөнхий мэдээлэл			
1	Төсөл хэрэгжүүлэгч компани	Засагчандмань Майнз ХХК	
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	9011238027	
3	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-015594	
4	Ашигт малтмалын төрөл	Төмөр (Зэс, алт)	
5	Ордын байршил	Дорноговь аймгийн Дэлгэрэх сум	
6	Орд ашиглалтын хугацаа	12 жил	
Геологийн хэсэг			
7	Нөөцийн дүгнэлтийн дугаар, огноо	ХХ-11-02 тоот дүгнэлт, 2016.10.24	
8	Нөөц бүртгэх тухай тушаалын дугаар, огноо	Н/03 тоот тушаал, 2016.11.11	
9	Нийт геологийн нөөц - MV-015594 (B+C)	сая.тн	68.8
10	Төмрийн хэмжээ	сая.тн	10.67
11	Зэсийн хэмжээ	мян.тн	154.27
12	Алтны хэмжээ	тн	6.34
13	Мөнгөний хэмжээ	тн	95.35
14	Молибденийн хэмжээ	тн	1,703.86
Ил уурхайн технологийн хэсэг			
15	Уурхайн жилийн хүчин чадал	сая.тн	2.0
16	Ил уурхайн хүрэн дэх нөөц	сая.тн	27.8
17	Хүдрийн хаягдлын хэмжээ, 3.88%	сая.тн	1.08
18	Хүдрийн бохирдлын хэмжээ, 5.82%	сая.тн	1.62
19	Овоолгод хураагдах нөөц	сая.тн	8.1
20	Үйлдвэрлэлийн нөөц	сая.тн	20.14
21	Уурхайн нийт хөрс хуулалт	сая.м ³	50.27
22	Хөрс хуулалтын дундаж коэффициент	м ³ /тн	1.8
23	Ашиглалтын систем	Автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем	
24	Жилийн ажиллах хоногийн тоо	Хоног	355
25	Ээлжийн тоо	Ээлж	2
26	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12
27	Жилд ажиллах цаг	Цаг	8,520
28	Ажиллагсдын тоо	Хүн	377
Баяжуулах технологийн хэсэг			
29	Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал:		
30	Исэлдсэн хүдэр баяжуулах үйлдвэр	мян.тн	800
31	Анхдагч хүдэр баяжуулах үйлдвэр	мян.тн	1,200



32	Баяжуулах технологи		
33	Исэлдсэн хүдэр	Хуурай соронзон баяжуулалт	
34	Анхдагч хүдэр	Флотаци, нойтон соронзон баяж	
Дэд бүтэц			
35	Цахилгааны эх үүсвэр	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	
36	Цахилгааны жилийн хэрэглээ	мян.кВт.жил	57,884.1
37	Ундны усны эх үүсвэр	Гүний худаг	
38	Ил уурхайн зам талбайн усалгааны эх үүсвэр	Уурхайн шүүрлийн ус	
39	Нийт усны хэрэглээ	мян.м ³	4,308.3
Эдийн засаг			
40	Төслийн нийт хөрөнгө оруулалт	тэрбум төг	406.7
41	Нийт зардал	тэрбум төг	1,409
42	Нийт борлуулалтын орлого	тэрбум төг	2,209
43	Улс орон нутгийн төсөвт оруулах нийт орлого	тэрбум төг	546.6
44	Ирээдүйн мөнгөний одоогийн үнэ цэнэ NPV=10%	тэрбум төг	69.2
45	Хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн норм, IRR%	%	12
46	Хөрөнгө оруулалт нөхөх хугацаа	жил	5.1
47	1 тн хүдрийн бүрэн өөрийн өртөг	төг/тн	69,923
48	1м ³ уулын цулын бүрэн өөрийн өртөг	төг/м ³	24,280

1.4 ОЛБОРЛОЛТЫН ТЕХНОЛОГИ

1.4.1 Ордын уул-техникийн нөхцөл

Чандмань уулын төмөр (зэс, алтны)-н хүдрийн ордын голлох хүдрийн биетүүд нь газрын гадаргууд шууд гарш үүсгэсэн байрлалтай оршдог. Хүдрийн биетүүд нь баруун урдаас зүүн хойш чиглэсэн суналтай, зүүн урагш 40-450-н уналтай хоорондоо ойрхон зайтай цуварч зэрэгцсэн байрлалтай оршдог.

Хүдрийн биетүүд нь газрын гадаргууд ил гарштай, цул үргэлжлэн тогтсон, тасралт эвдрэлд харьцангуй бага өртсөн бөгөөд ордыг ил аргаар ашиглахад гидрогеологийн хувьд ямар нэгэн хүндрэл гарахааргүй байна.

- Хүдрийн эзлэхүүн жин – 3.6 тн/м³
- Хөрсний эзлэхүүн жин – 2.85 тн/м³
- Хөрсний чулуулгийн бат бэхийн коэффициент /Профессор М.М.Продотьяконовын ангиллаар/ – f=9-13

“Чандмань уул”-ын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордын голлох хүдрийн биетүүд нь газрын гадаргууд шууд гарш үүсгэсэн байрлалтай оршдог. Хүдрийн биетийн гүний байршил, ашигт эрдсийн агуулга болон түүний тархалт, нөөцийн хэмжээ зэргээс хамааруулан ил уурхайн олборлолтын арга илүү тохиромжтой байна. Гоулдмэн Прожектын туршлага болон ижил төстэй хүдрийн биеттэй харьцуулахад ил уурхайн олборлолтын арга нь хүдрийн биетийг нээх болон олборлолтыг үр ашиг өндөртэй гүйцэтгэхэд нэн тохиромжтой гэж үзсэн.

Уурхайн төлөвлөлтөд зэсийн зах зээлийн үнийг 8050 \$/т, алтны үнийг 1,845\$/унц мөнгөний үнийг 23.5\$/унц байхаар тооцоолсон ба В болон С зэрэглэлийн нөөцийг олборлон баяжуулахаар тооцсон байна.

1.4.2 Геотехникийн судалгаа

Анхан шатны геотехникийн үнэлгээг Чандмань уулын ордын ил уурхайд зориулан Интернэшнл Майнинг Консалтинг ХХК боловсруулсан байна. Энэхүү урьдчилсан үнэлгээ нь цугларсан геотехникийн мэдээлэл болон чулуулгийн шинж чанарын дүн шинжилгээнд тулгуурлан уурхайн хажуугийн өнцгийн хэмжээснүүдийг тодорхойлсон байна.



Уг судалгааны ажлын үр дүнг үндэслэн уурхайн хажуугийн өнцгийг тодорхойлсон бөгөөд дараах хүснэгтэд уурхайн хажуугийн параметруудийг үзүүлэв.

Хүснэгт 1-2. Зөвлөмж болгосон ил уурхайн хажуугийн өнцөг

Үзүүлэлт	Утга
Доголын хамгийн их зөвшөөрөгдөх өндөр	15
Доголын хажуугийн өнцөг	65
Аюулгүйн тавцангийн хамгийн бага өргөн	5
Зам хоорондын хамгийн их зөвшөөрөгдөх өнцөг	50

1.4.3 Ил уурхайн оновчлол

Төслөөр хуурай баяжуулах үйлдвэрийн төслийн хүчин чадал нь 2,300 тн/хоног, нойтон баяжуулах үйлдвэрийн төслийн хүчин чадал нь 3,400 тн/хоног байна. Хоёр үйлдвэр нь дундаа нэг бутлууртай байх бөгөөд бутлуурын төслийн хүчин чадал нь 5,700 тн/хоног байна. Уурхай баяжуулах үйлдвэрээс 55% агуулга бүхий төмрийн баяжмал (исэлдсэн хүдрийг баяжуулна), нойтон баяжуулах үйлдвэрээс 65% агуулга бүхий төмрийн (анхдагч хүдрийг баяжуулна) болон зэсийн (зэсийн баяжмал нь алт болон мөнгө агуулна) гэсэн гурван төрлийн баяжмал үйлдвэрлэж хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр рүү шилжүүлнэ.

Ил уурхайн оновчлолын процессын үр дүнд бүтээгдэхүүний үнэ 30%-аас 200% хооронд 5% интервалтайгаар хэлбэлзэхэд үнээс хамаарсан 35 хувилбар бүхий уурхайн хүрэнүүдийг үүсгэсэн. Эдгээр хүрээний хувилбарууд дээр Лерчс – Гроссмэний шинжилгээг гүйцэтгэн уурхайг нээхэд хамгийн тохиромжтой хэсэг, олборлолт явуулах оновчтой дараалал, үе шатны болон эцсийн уурхайн хүрээ хязгаарын сонголтыг хийсэн. Бүтээгдэхүүний үнэ бага байхад харьцангуй бага гүнтэй уурхай үүсгэх бол бүтээгдэхүүний үнэ ихсэх тусам уурхайн хүрээ хязгаар томорно.

Уурхайн хүрээ хязгаарын оновчлол нь ордын үндсэн өгөгдөл болон хязгаарлалтуудад тулгуурлан хамгийн үр ашиг өндөртэй уурхайн хүрээг тодорхойлох процесс юм. Уурхайн оновчтой хүрээ хязгаарыг Лерч Гроссмэний аргачлалын дагуу олборлолтын, баяжуулалтын болон удирдлагын зардал, металл авалт, уурхайн хажуугийн өнцөг болон урт хугацааны металлын үнийн төсөөлөлд үндэслэн тодорхойлдог.

Ил уурхайн оновчлол нь өгөгдсөн өгөгдөл болон хязгаарлалтуудад тулгуурлан хамгийн их ашиг бүхий уурхайн хүрээ хязгаарыг тодорхойлох процесс юм. Ил уурхайн оновчлолын процессын үр дүнд бүтээгдэхүүний үнэ 30%-аас 200% хооронд 5% интервалтайгаар байхад хамаарах үнээс хамаарсан хүрээний хувилбаруудыг үүсгэсэн. Бүтээгдэхүүний үнэ бага байхад харьцангуй бага гүнтэй уурхай үүсгэх бол бүтээгдэхүүний үнэ ихсэх тусам уурхайн хүрээ хязгаар томордог. Уг үүсгэсэн уурхайн хүрээний хувилбаруудаас уурхайн эцсийн, үе шатны болон хэтийн ирээдүй бүхий хүрээ хязгааруудын сонголтыг хийнэ.

Ил уурхайн оновчлолыг Whittle 4X Optimizer программыг ашиглан геологийн блок модель дээр доорх алхмуудын дагуу гүйцэтгэсэн:

- Оновчлолд тусгах хязгаарлалтууд тодорхойлох
- Уурхайн геотехникийн параметрууд, хаягдал болон бохирдлыг тодорхойлох
- Металлургийн хэмжээснүүдийг тодорхойлох
- Уурхайн үйл ажиллагааны зардлыг тооцох
- Бусад зардлуудыг тооцох
- Бүтээгдэхүүний үнэ, хайлуулалтын цэвэр буцаалтыг тодорхойлох
- Ил уурхайн оновчлолын тооцооллыг гүйцэтгэх, үр дүнгээр тайлан гаргах


Хүснэгт 1-3. Хуурай баяжуулах үйлдвэрийн үзүүлэлтүүд

№	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Утга
Исэлдсэн хүдэр			
1	Баяжмал дах төмрийн агуулга	Fe, %	55.03
2	Баяжмал дах зэсийн агуулга	Cu, %	0.17

№	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Утга
3	Баяжмал дах төмрийн металл авалт	%	62.15
4	Баяжмал дах зэсийн металл авалт	%	25.33

Хүснэгт 1-4. Нойтон баяжуулах үйлдвэрийн үзүүлэлтүүд

№	Хүдэр	Бүтээгдэхүүний нэр	Нэгж	Утга
Зэсийн баяжмал				
1	Исэлдсэн	Баяжмал дах зэсийн агуулга	Cu, %	22.90
2		Баяжмал дах алтны агуулга	Au, гр/тн	9.65
3		Баяжмал дах мөнгөний агуулга	Ag, гр/тн	175.48
4		Баяжмал дах алтны агуулга	Fe, %	3.84
5		Баяжмал дах зэсийн металл авалт	%	70.55
6		Баяжмал дах алтны металл авалт	%	61.24
7		Баяжмал дах мөнгөний металл авалт	%	83.49
8		Баяжмал дах төмрийн металл авалт	%	1.01
9	Анхдагч	Баяжмал дах зэсийн агуулга	Cu, %	23.57
10		Баяжмал дах алтны агуулга	Au, гр/тн	3.75
11		Баяжмал дах мөнгөний агуулга	Ag, гр/тн	185.70
12		Баяжмал дах алтны агуулга	Fe, %	9.22
13		Баяжмал дах зэсийн металл авалт	%	91.68
14		Баяжмал дах алтны металл авалт	%	46.21
15		Баяжмал дах мөнгөний металл авалт	%	43.18
16		Баяжмал дах төмрийн металл авалт	%	1.01
Төмрийн баяжмал				
17		Баяжмал дах төмрийн агуулга	Fe, %	65.06
18		Баяжмал дах зэсийн агуулга	Cu, %	0.03
19		Баяжмал дах алтны агуулга	Au, гр/тн	0.08
20		Баяжмал дах мөнгөний агуулга	Ag, гр/тн	4.60
21		Баяжмал дах төмрийн металл авалт	%	53.28
22		Баяжмал дах зэсийн металл авалт	%	0.69
23		Баяжмал дах алтны металл авалт	%	10.09
24		Баяжмал дах мөнгөний металл авалт	%	18.22



Зураг 1-3. Оновчтойгоор тодорхойлсон уурхайн хүрээ



1.5 БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

1.5.1 Хүдэр хүлээн авах, бутлалт

Уурхайгаас тээвэрлэн ирсэн хүдрийг хүлээн авах талбайд буулгаж, анхан шатны бутлуураар бутална. Дараагийн шатанд шаардлагатай ширхэглэлд хүргэх зорилгоор хоёрдогч бутлалт, шигшилт хийгдэнэ. Энэ шатанд ус ашиглахгүй. Тоосжилтыг бууруулах зорилгоор тоос дарах болон битүүмжлэлтэй систем ашиглана.

1.5.2 Хуурай баяжуулалт

Бутлагдсан хүдрийг хуурай соронзон баяжуулалтад оруулж төмөр агуулгатай хэсгийг ялгана. Энэхүү процесс нь ус ашиглахгүй бөгөөд механик болон соронзон орны нөлөөгөөр эрдсийг ангилна. Хуурай баяжуулалт нь усны хэрэглээ багатай, байгаль орчны нөлөөлөл харьцангуй бага технологи юм.

Хуурай баяжуулах үйлдвэрийн баяжуулалтын технологиос гарах эцсийн бүтээгдэхүүн нь төмрийн баяжмал байх ба бүтээгдэхүүн гаргалтын тооцоог доорх хүснэгтэд үзүүлэв. Технологийн туршилтын тайланд үндэслэн тооцсон технологийн тооцооллоор 55.03%-ийн агуулгатай төмрийн баяжмалыг 62.15%-ийн металл авалттайгаар байхаар тооцсон.

Баяжуулах үйлдвэрээс төслийн нийт хугацаанд 36.61%-ийн дундаж агуулгатай 7.20 сая.тн исэлдсэн хүдрийг 3 шатны хуурай соронзон баяжуулалтаар баяжуулах ба жилд дунджаар 281 мян.тн баяжмал үйлдвэрлэнэ.

1.5.3 Нойтон баяжуулалт

Нунтаглалт

Нойтон баяжуулалтын шатанд шилжсэн хүдрийг тээрэмд ус нэмэн нунтаглана. Нунтаглалтын зорилго нь ашигт эрдсийг сулруулж, флотацийн шатанд ялгарах боломжийг бүрдүүлэхэд оршино. Зутангийн хатуугийн агууламжийг технологийн шаардлагад нийцүүлэн тохируулна.

Бутлагдсан хүдрийг хяналтын ангилалттай 1 шатны нунтаглалтаар -0.074 мм-ийг 70% хүртэл нунтаглан үндсэн флотацид оруулна. Үндсэн флотацийн хам баяжмалыг хяналтын ангилалттай 1 шатны нунтаглалтаар -0.045 мм ийг 90% хүртэл дахин нунтаглан 2 шатны цэвэрлэгээний флотациар баяжуулан зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Хоёрдугаар шатны цэвэрлэгээний флотацийн хаягдал нь эхний шатны цэвэрлэгээний флотацийн тэжээл болно.

Флотаци

Флотацийн процесст натрийн бутил ксантогенат (SBX), аммоний дибутил дитиофосфат (ADD), терпений тос болон CaO ашиглана. Үндсэн, хяналтын болон цэвэрлэгээний флотацийн шат дараалалтайгаар зэс болон сульфидын эрдсийг ялган баяжмал гарган авна. Урвалжийн тунг автомат системээр хянана.

Өтгөрүүлэлт, шүүлт

Флотацийн баяжмал болон хаягдлыг өтгөрүүлэгчид оруулж хатуу, шингэн фазыг ялгана. Тунгалаг усыг эргэлтийн системд буцаан ашиглана. Баяжмалыг шүүлтүүрээр шүүж чийгийг бууруулсны дараа агуулах, тээвэрлэлтэд шилжүүлнэ.

Зэсийн болон төмрийн баяжмалыг өтгөрүүлэгч рүү өгч 55%-ийн хатуулагтай болтол өтгөрүүлсний дараа өтгөрүүлэгчээс гарсан баяжмалыг фильтр прессээр оруулж 85%-ийн хатуулагтай болтол усгүйжүүлнэ. Нойтон баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэгч рүү өгч 55%-ийн хатуулагтай болтол өтгөрүүлсний дараа өтгөрүүлэгчээс гарсан хаягдлыг фильтр



прессээр оруулж 80%-ийн хатуулагтай болтол усгүйжүүлэн хөрсний овоолгын хажууд тусгайлан бэлдсэн талбайд булшилна.

1.5.4 Бүтээгдэхүүн гаргалт

Анхдагч хүдэр

Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөөг технологийн туршилт, тоо-чанарын тооцоонд үндэслэн тооцсон бөгөөд жилд дунджаар 1.2 сая.тн анхдагч хүдрийг баяжуулж 3.09%-ийн гарцтай, 23.57%-ийн Си-ийн агуулгатай, 4.83 гр/тн-ийн Ау-ийн агуулгатай, 67.47 гр/тн-ийн Аг-ийн агуулгатай, 5.77%-ийн Фе-ийн агуулгатай, 1,345.49 гр/тн-ийн Мо-ийн агуулгатай, 39.97 мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Мөн 14.44%-ийн гарцтай, 0.04%-ийн Си-ийн агуулгатай, 0.23 гр/тн-ийн Ау-ийн агуулгатай, 6.09 гр/тн-ийн Аг-ийн агуулгатай, 65.06%-ийн Фе-ийн агуулгатай, 7.60 гр/тн-ийн Мо-ийн агуулгатай, 186.91 мян.тн төмрийн баяжмал үйлдвэрлэнэ.

Исэлдсэн хүдэр

Хуурай баяжуулах үйлдвэрийн баяжуулалтын технологиос гарах эцсийн бүтээгдэхүүн нь төмрийн баяжмал байх ба бүтээгдэхүүн гаргалтын тооцоог доорх хүснэгтэд үзүүлэв. Технологийн туршилтын тайланд үндэслэн тооцсон технологийн тооцооллоор 55.03%-ийн агуулгатай төмрийн баяжмалыг 62.15%-ийн металл авалттайгаар байхаар тооцсон байна. Төсөл хэрэгжих явцад баяжуулах үйлдвэрээс 48-55%-ийн агуулгатай баяжмал үйлдвэрлэн экспортод гарах боломжтой. Баяжуулах үйлдвэрээс төслийн нийт хугацаанд 36.61%-ийн дундаж агуулгатай 7.20 сая.тн исэлдсэн хүдрийг 3 шатны хуурай соронзон баяжуулалтаар баяжуулах ба жилд дунджаар 281 мян.тн баяжмал үйлдвэрлэнэ.

1.5.5 Усны эргэлтийн систем

Баяжуулах үйлдвэр нь хаалттай эргэлтийн усны системтэй. Нийт усны ойролцоогоор 92%-ийг дахин ашиглаж, 8%-ийг нөхөн сэлбэлтээр хангана. Ингэснээр шинэ усны хэрэглээг бууруулна.

1.6 ДЭД БҮТЭЦ

Усан хангамж: Уурхайн усан хангамжийн усны эх үүсвэрийг тогтоох зорилгоор гидрогеологийн судалгааны ажлыг 2010-2011 онуудад Тэхт Оргил Дрийлинг ХХК болон Засагчандмань Майнз ХХК хамтран газрын доорх усны эрэл хайгуулын судалгааг явуулж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломжтой усны нөөцийг 10 л/с хэмжээтэйгээр тогтоосон байна. Уурхайн хэрэглээний тооцоогоор уурхай нь хоногт дунджаар 1.8 мян.м3/хоног ус хэрэглэх ба гидрогеологийн судалгаагаар тогтоогдсон 10 л/с-н ундарга бүхий 3 цооног нь уурхайн усан хангамжийн хэрэгцээг бүрэн хангахаар байна. Мөн аль нэг худагт болзошгүй эрсдэл гарах үүднээс 4 дэх цооног нь нөөцөд байх бөгөөд 4 цооногийн нийт ундарга 21.5 л/с байна.

Цахилгаан хангамж: Чандмань уулын төмөр (зэс, алт)-н орд нь Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутагт орших бөгөөд уг ордын цахилгаан хангамжийг Бор-Өндөр сумын 110/35/6кВ н дэд станцаас 110кВ –н 140 км урт ЦДАШ бүрэн татаж суурилуулаад байна.

Уурхайн баяжуулах үйлдвэрийн дэргэд 35/6 кВ – ийн трансформаторын дэд станц байгуулахаар төлөвлөн уурхайн хотхон, засварын цех зэргийг 6 кВ –ийн агаарын шугамаар хангана.

Дулаан хангамж: Дулааны гол хэрэгцээ нь хүдэр баяжуулах үйлдвэр, үйлдвэрийн байгууламжтай залгаа баригдаж буй оффисын барилга, засварын газар, үйлдвэрийн дэргэдэх лаборатори болон хотхоны хэсэгт ажилчдын орон сууцууд, гал тогоо, эмнэлэг, халуун ус, угаалгын газар гэх мэт байна. Дулаан хангамжийн асуудлыг ажилчдын тосгоны хувьд уурын зуух болон цахилгаан халаагуураар хослуулан халаана.

Холбоо дохиолол: Уурхайн инженер техникийн ажилчдыг богино долгионы холбоогоор хангаж, уурхайн орчмыг бүрэн камержуулна. Энэ нь хяналтыг сайжруулах ба аваар осол болон



гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх сайн нөлөөтэй. Мөн уурхайг өндөр хурдны интернэт, зурагт радио зэрэгт холбож ажилчдын ая тух болон ажлын түргэн шуурхай байдлыг ханган ажиллана.

Дотоод болон гадаад тээвэр: Уурхайн талбайгаас хуурай болон нойтон баяжуулах үйлдвэр лүү 1 км орчим дотоод замаар тээвэр хийнэ. Гадаад тээврийг 2 сонголттой хийхээр төлөвлөж байгаа. Үүнд:

1. Алтанширээт парк (баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын бүс, төмөр замын өртөөтэй) хүртэл 108км сайжруулсан шороон замаар ачааны авто машинаар тээвэрлээд, Алтанширээт парк дээр төмөр замд шилжүүлэн ачиж, БНХАУ-ын эрэн боомт хүрнэ. Алтанширээт хүрэх маршрутын хавсаргав.
2. Төмөр зам нь жил бүр тодорхой квоттой байдаг учир квот дүүрсэн болон дууссан үед Алтанширээт паркаас ачааны машинаар үргэлжлүүлэн Эрэн боомт хүрэх эсвэл Бор-өндөр хүртэл 140км сайжруулсан шороон замаар ачааны авто машинаар тээвэрлэн, Бор-өндөр төмөр замын өртөө дээр төмөр замд шилжүүлэн ачиж, БНХАУ-ын Эрэн боомт хүрнэ.



БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй: Төслийн талбай нь Төв Азийн заримдаг цөл, цөлийн их мужид харьяалагдана. Гадаргын тогтцын хувьд Алтайн өвөр болон ар говиос ялгаатай, харин Монголын дорнод талтай төстэй байна. Учир нь ухаа гүвээт тал эндхийн ихэнх нутгийг эзэлнэ. Ийм тал говийн бүсийн хойд ихэнх хагасыг хамрахын зэрэгцээ өмнөд хагаст ч дайралдана. Гадарга нь хэвгий багатай, ил гарсан хад чулуу бараг байхгүй ухаа гүвээний хооронд их бага янз бүрийн хэмжээтэй хотос, тал газар байх бөгөөд түүнд хужир марз цөөнгүй тохиолдоно.

Уур амьсгал: Төслийн талбай байрлах Дорноговь аймаг уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их утга 33.6°C, өвөлдөө хүйтэн боловч зундаа аагим халуун болдог байна. Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг.

Усан орчин: Төслийн талбайн газрын доорх усны нөөцийн тархалтаар газрын доорх усны түвшин <5мм/жил бүсэд хамаарагдаж байна. Чандмань уулын төмрийн хүдрийн олборлолт, баяжуулалтад хэрэглэгдэх усны нөөц бүхий хөндий нь Гэр чулуутын зурвас хөндийд төвлөрсөн бөгөөд газрын доорх усны хуримтлалын талбайг бүрдүүлдэг. Уурхайн гүний олборлолт 1060 м-ийн үнэмлэхүй түвшнээс доош явагдах нөхцөлд ан цавын шүүрлийн ус үүсэх боломжтой ч, одоогийн олборлолт, баяжуулалтын түвшинд усжилт ихгүй тул ашиглалт боломжтой гэж дүгнэжээ.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай нь 1,220-1,260 метрийн үнэмлэхүй өндөрт орших намхан толгод болон тэдгээрийн бэл хормой дагуух бүсэд байрладаг. Хөрсний хувьд Монгол орны хөрсний ангиллын дагуу хээрийн бүсийн сайргархаг хүрэн болон ердийн хүрэн хөрсний хэв шинж давамгайлах ба төслийн талбайд дараах хөрсний төрөл зонхилж байна. Төслийн талбайд тархсан Сайргархаг хүрэн хөрс, Ердийн хүрэн хөрс нь нийтдээ шим тэжээлийн агууламж багатай, уур амьсгалын нөхцөлтэй уялдан ихэвчлэн бэлчээрийн зориулалтаар ашиглагддаг. Хөрсний тархалтын төлөв байдлыг дээрх зураглалд үзүүлэв.

Ургамлан нөмрөг: Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг дэвсгэр нь Монгол орны ургамал-газарзүйн тойргоор Дорнод говийн тойрогт багтдаг. Төслийн талбай нь газрын гадаргын хувьд нам толгод, ухаа гүвээ болон тэдгээрийн хоорондох тэгш тал бүхий газарт байрлах ба ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө цөлөрхөг хээрийн ургамалжилтай бөгөөд ургамалжлыг цөлөрхөг хээрийн хэв шинж бүхий хялганат-сэдэргэнэт хэвшилийн Хялгана-хамхуул-сэдэргэнэт бүлгэмдэл, Хялгана-харганат хэвшилийн Хялгана-шарилж-харганат болон Хялгана-бударгана-харганат бүлгэмдэл болгон ангиллаа. Төслийн талбай нь цөлөрхөг хээрийн бүсэд багтах бөгөөд судалгааны явцад нийт 8 овогт хамаарах 14 төрөл, 18 зүйл ургамал бүртгэгдсэн.

Амьтны аймаг: Төслийн талбай нь амьтны газарзүйн тойргийн мужлалаар Хойд говь буюу их нууруудын хотгорын тойргийн зүүн өмнөд хэсэгт хамаарна. Том амьтдаас цагаан зээр өвлийн улиралд жил бүр харилцан адилгүй (2025 оны өвөл бараг харагдаагүй), зарим жилүүдэд жилийн 4 улиралд суурин байх тохиолдол бий. Мэрэгч амьтдаас шар чичүүл, үлийн цагаан оготно түгээмэл тархсан учир түүгээр идээшлэгч үнэг, хярс элбэг бол саарал чоно гүйдлийн тохиолдоно. Шувуудаас суурин, болон эрт нүүдэг зүйлүүд зонхилсон бөгөөд 6 баг, 18 овогт хамаарах 38 зүйл бүртгэгдсэн байна. Ховор амьтад гэвэл шувуудаас хулан жороо, идлэг шонхор, хөхтнөөс мануул, саарал чоно, цагаан зээрийг дурдаж болохоор байна. Мөлхөгчдөөс 2 салбар баг, 5 овог, 7 төрөлд хамаарах 7 зүйлийн мөлхөгчид идээшин амьдарч байна.

Дорноговь аймаг: Дорноговь аймаг нь 1931 онд байгуулагдсан. Аймгийн төв Сайншанд сум нь улсын нийслэл Улаанбаатар хотоос 450 км-т оршдог. Монгол Улсын зүүн өмнөд цэгт нийт 109.5 мянган км² нутаг дэвсгэр талбайд байрлах бөгөөд Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь,



Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. Дорноговь аймаг нь нийт 109.5 мянган км² нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд засаг захиргааны хувьд нийт 14 сум, 65 багтай. Аймгийн хүн амын тоо ойролцоогоор 80 гаруй мянгад хүрдэг бөгөөд мал аж ахуй давамгайлсан эдийн засагтай. Үүнээс гадна төмөр зам, авто замын сүлжээ сайн хөгжсөн нь дотоод, гадаад худалдаа, тээврийн чухал зангилаа болж өгдөг.

Сүүлийн 10 жилийн хугацаанд (2015–2024) Дорноговь аймагт хүн амын тоо тогтвортой өсөж, 2015 онд 63,308 байснаа 2024 онд 71,691 болж, 13.2%-ийн өсөлт үзүүлжээ. Энэ нь улсын дундажтай харьцуулахад бага зэрэг доогуур байгаа ч бүсийн дундажтай ойролцоо үзүүлэлттэй байна.

Дэлгэрэх сум: Дорноговь аймгийн зүүн хэсэгт орших Дэлгэрэх сум нь Улаанбаатараас 583 км, аймгийн төв Сайншандаас 141 км зайд байрладаг. Нийт газар нутгийн хэмжээ 4,858.10 км² бөгөөд 2022 оны хүн амын тооллогоор 1,941 хүнтэй хэмээн бүртгэгдсэн байна. Сум нь Аманшанд, Бумбат, Хонгор, Цагаанханд гэсэн дөрвөн багийн нутаг дэвсгэрт хуваагдана. Энэхүү сум 1913 онд “Дэлгэрэх” нэртэйгээр байгуулагдаж, 1915 онд “Аварга уулын Дэлгэрэх сум”, 1918 онд “Дэлгэрэх-Аварга уулын сум” гэж нэрлэгдэж байсан бол 1931 оноос өнөөгийн нэршлээ хадгалж иржээ. Байгалийн хувьд Дэлгэрэх сум нь говь, тал хээрийн бүсийг хослуулсан өвөрмөц тогтоцтой. Аманшанд багийн нутагт байгалийн ховор тогтоц болох зургаан талт чулуулгийн давхарга оршдог бөгөөд энэ нь геологийн сонирхолтой дурсгалд тооцогдоно. Мөн “Хайлансангийн хурал” нэртэй бурхны жижиг дуганы туурь хадгалагдан үлдсэн нь соёлын өвийн чухал хэсэг юм. Нийгмийн үйлчилгээний хувьд 1934 онд “Хонгор” хэмээх газарт байгуулагдсан эрүүл мэндийн төв нь өнөөдөр сумын иргэдэд суурь эрүүл мэндийн тусламж үзүүлдэг бөгөөд тус сум нь байгаль, түүх, соёлын өвөрмөц тогтоцтой, нийгмийн үйлчилгээний бүтэцтэйгээр Дорноговь аймгийн зүүн хэсгийн чухал сум юм.

Дэлгэрэх сумын хүн ам сүүлийн 10 жилийн хугацаанд харьцангуй тогтвортой, 2015 онд 1,859 байсан бол 2024 онд 1,931 болж, ердөө 3.9%-иар өссөн нь бараг тогтвортой байдалтай байгааг харуулж байна. Харин сумын багуудын хувьд 1-р баг Цагаанхад 2015 онд 443 хүнтэй байсан бол 2024 онд 482 болж 8.8%-иар өссөн. 2-р баг Аман шанд харьцангуй хэлбэлзэлтэй, 2015 онд 673 байсан бол 2024 онд 673 хэвээр байгаа ч дунд үедээ хүн ам буурч байгаад дахин нэмэгдсэн байна. Энэ нь хүн амын шилжилт хөдөлгөөн идэвхтэй явагдаж байгааг харуулж байна.



БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Уурхай нь 12 жилийн хугацаанд ажиллах ба жилд 1200 мян,тн хүдэр баяжуулах үед тоос, тоосонцор үүснэ.
- Ил уурхайн тэсэлгээний ажил болон олборлолтоос тоосжилт үүснэ. Тоосжилт олборлолтын эх үүсвэрээс дунджаар 3 км зайд тархана.
- Ашиглалтын жилүүдэд уурхайн дотоод хөрс тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлнө.
- Орд ашиглалтын хугацаанд 933 мян.м3 шимт хөрс хуулж хүдэр олборлоно. Үүнээс хөрс буулгах, ачих, овоолгод байршуулахад тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлнө.
- Уулын ажлын гүйцэтгэлд экскаватор, автосамосвал, бульдозер зэрэг хүнд даацын машинуудыг ашиглах ба тэдгээрээс утаа үүсэж орчны агаарын чанарт нөлөөлнө.
- Хүдрийг шигшиж, ангилах, бутлах, баяжуулах үед тоосжилт үүснэ.
- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас хуурай хаягдал хуримтлагдана. Энэ нь цаг агаарын хуурай, салхитай үед хатаж, хийсэж тоосжилт үүсгэж болзошгүй.

3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- ШТМ, барилгын түүхий эд, материал, аюултай хаягдлуудын санамсаргүй болгоомжгүй байдлаар асгарах, гоожих, алдагдсаны улмаас хөрс бохирдуулж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагааны хүрээнд 325.4 га талбай эвдрэлд өртөнө.
- Нийт 933 мян.м3 хөрс хуулснаар газрын гадаргад хоосон (ухсан) орон зай үүснэ
- Уурхайн хэмжээнд ажиллаж буй хүнд даацын машин механизмын үйл ажиллагааны улмаас хөрс болон хүдэр тээвэрлэхэд газрын гадарга талхлагдах
- Ахуйн болон аюултай хог хаягдлын түр хадгалах цэг стандартын дагуу байгуулаагүй, тогтмол цэвэрлэгээ, ариутгал хийхгүй байх, эсвэл стандарт шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж барих нөхцөлд хадгалсан тохиолдолд ойр орчмын газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.

3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Төслийн үйл ажиллагаа дээд хүчин чадлаараа ажиллах үед унд ахуй усны хэрэглээнд хоногт 55.32 м3 ус ашиглана.
- Ногоон байгууламж услах усны хэрэглээнд хоногт 52 м3 ус ашиглана.
- Ус ашиглах боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглах тохиолдолд газрын доорх усны түвшинд бууралт явагдах
- Ус ашиглалтаас үүдэлтэй хөрсний чийгийн баланс алдагдах, газрын хагарал, хөрсний суулт үүсэх
- Төслийн үйл ажиллагаа дээд хүчин чадлаараа ажиллах үед зам талбайн тоосжилт дарах усны хэрэглээнд хоногт 53 мян.м3 ус ашиглана.
- Төслийн үйл ажиллагаа дээд хүчин чадлаараа ажиллах үед зам талбайн тоосжилт дарах усны хэрэглээнд хоногт 2,943.4 мян.м3 ус ашиглана.
- Ахуйн болон технологийн бохир усны хадгалалт шаардлага хангаагүй тохиолдолд усан орчин бохирдох.
- Химийн бодис болон аюултай хог хаягдал ил задгай асгарснаас шалтгаалан усан орчин бохирдох



3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Уурхайн олборлолтоор 76.1 га эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устгах
- Хөрсний овоолго, шимт хөрсний овоолго, хүдрийн овоолгуудыг 244.1 га талбайд шимт хөрс овоолго үүсгэснээр ургамлан нөмрөг устгах.
- Уурхайн үйл ажиллагаа, баяжуулах үйлдвэр байгуулахаар 8.7 га талбайн шимт хөрс хуулснаар ургамлан нөмрөг устгах.
- Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох.
- Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарсны улмаас ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй.
- Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих
- Амьтдын амьдрах орчин алдагдах, доройтох, уурхайн ухсан талбайд гэрийн мал болон зэрлэг амьтан эндэх магадлалтай
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, техникийн хөдөлгөөнөөс зэрлэг амьтдад дайжих
- Уурхайн болон ажилчдын тээврийн зам нь амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад учруулах, нэмэлт нөлөөлөл үүсгэх
- Биологийн олон янз байдлын өнөөгийн төрөл, зүйлийн бүтэц алдагдах, жишээ нь хүнд ойромсог буюу хэрээ, бор шувууны овгийн шувууд олноор цугларах

3.5 ХОГ ХАЯГДЛЫН УЛМААС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Уурхайн хүрээнд хүнд даацын тоног төхөөрөмж ашиглан олборлолт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд хүдэр, хөрс тээвэрлэлт, ачиж, буулгах, угсралтын ажил хийх зэрэг үйл ажиллагаанаас дуу чимээ, чичиргээ, гэрлийн бохирдол үүсэж болзошгүй.
- Уурхайн төслийн үйл ажиллагааны явцад гарах хатуу хог хаягдлын тооцоог хийхдээ нэг хүн өдөрт дунджаар 0.4 кг ахуйн хог хаягдал гаргах ба барилгын ажилд дээд тал нь 377 хүн ажиллана. 1 хүн өдөрт 0.4 кг хог хаягдал гаргана гэж үзвэл жилд 55.04 тн хог хаягдал үүснэ.
- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, засвар үйлчилгээнээс хаягдал тос, тосолгооны материал, хаягдал поошиг, аккумулятор зэрэг аюултай хог хаягдал үүснэ.
- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, засвар үйлчилгээнээс хаягдал тос, тосолгооны материал, хаягдал поошиг, аккумулятор зэрэг аюултай хог хаягдал үүснэ.
- Ахуйн болон аюултай хог хаягдлын түр хадгалах цэгийг стандартын дагуу байгуулаагүй, тогтмол цэвэрлэгээ, ариутгал хийхгүй байх, эсвэл стандарт шаардлага хангаагүй нөхцөлд хадгалсан тохиолдолд ойр орчмын газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.
- Үйлдвэрийн бутлах, шигших, тээвэрлэх, баяжуулах тоног төхөөрөмжийн тасралтгүй ажиллагаанаас дуу чимээ, механик доргилт үүсэж, ажиллах орчин болон ойр орчмын бүсэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй



БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Засагчандмань Майнз ХХК-ийн Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн 2026 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба 2026 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд **153,505,000 ₮** зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал, ₮
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,810,000
2.	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	21,600,000
3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Энгийн 10,840,000 Аюултай 6,000,000
4.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	9,170,000
5.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	2,000,000
6.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	60,880,000
7.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	18,000,000
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 20,205,000
Нийт зардал		153,505,000

4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Засагчандмань Майнз ХХК-ийн 2026 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт 35 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин болон ургамлан нөмрөг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэн 2026 оны БОМТ-



Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн
ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Хүснэгт 4-2-д тусгав.



Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<i>Агаарын чанар</i>									
1.	Хөрс хуулалт, тэвэрлэх, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсэж төсөл хэрэгжих орчны агаарын чанарт, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Уурхайн талбай	-	Нэгж усалгаа	ҮАЗ		Салхи ихээр босдог хавар, намрын улиралд 7 хоногт 1-2 удаа	2026-2030 оны БОМТ-ний 9.2.1-т тусгаснаар Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 4585:2025 MNS 5885:2008
2	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх	Уурхайн олборлолтын үед усалгаа хийх	Уурхайн ухаш, овоолгууд	-	Удаа	ҮАЗ		Олборлолтын үед	
3		Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөх	Уурхайн дотоод болон гадаад зам	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
4	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замаас тоосжилт үүсэх	Засаж сайжруулсан замаас өөр зам гаргахгүйн тулд MNS4597:2014. дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах ба бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах.	Уурхайн дотоод болон гадаад зам	ш	20	0.04	0.8	Жил бүрийн дотоод тээврийн замын төлөвлөлтөөс хамаарна.	
5		Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам дагуу хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих	Уурхайн дотоод болон гадаад зам	-	-	ҮАЗ		7 хоног бүр хурдны хяналтыг тавих	
6		Уурхайн дотоод болон гадаад шороон замын засвар арчилгааны тогтсон хуваарийн дагуу засаж сайжруулах	Уурхайн дотоод болон гадаад зам	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
7		Уурхайн дотоод тээврийн замд усалгааг хийх	Уурхайн дотоод болон гадаад зам	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
8	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Тээврийн хэрэгслүүдийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийж байх, утаа их ялгаруулдаг болон ашиглалтын хугацаа хэтэрсэн машин, техникийг ашиглахгүй байх	Тээврийн хэрэгслүүд	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
9	Хүдэр бутлах, дамжуулах, хөрсний овоолго үүсгэх үед тоосжилт үүсэх	Хүдэр бутлах, дамжуулах, хөрсний овоолго үүсгэх үед зориулалтын тоос дарах бодис хэрэглэх	Уурхайн талбай	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)									
10	Төслийн үйл ажиллагаагаар нийт 933 мян.м ³ шимт хөрс хуулна.	Шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	Төслийн талбай	-	га	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	MNS:5011:2020. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага Эрүүл ахуйн тухай хууль
11		Шимт хөрсний овоолгуудын дээд болон хажуу гадаргууг хэлбэржүүлэлт хийж, олон наст өвслөг ургамал тарих	Хөрсний овоолгууд	1	овоолго	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
12		Хөрсний овоолгуудын ойр орчимд тэмдэг тэмдэглэгээг хийх	Хөрсний овоолгууд	20	ш	0.04	0.8	1, 3, 5 дах жилд	
13		Хөрсний овоолгуудын талбайн хэмжээ, байршил зэргийг тусган бүртгэл хөтлөх.	Хөрсний овоолгууд	-	удаа	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
14	Хүнд машин механизм, машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдэл болох хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдох	Шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралтын дотоод журмыг боловсруулах	Төслийн талбай	-	-	ҮАЗ		Эхний жил журмыг боловсруулж, үйл ажиллагааны турш ажилчдад таниулан даган мөрдөнө.	MNS5850:2019.



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
15	Ашигт малтмалаас цацраг идэвхт бодис ялгарч болзошгүй	Олборлож буй ашигт малтмал дээр цацрагийн хэмжилт хийлгэх	Төслийн талбай	4	ш	0.045	0.18	Үйл ажиллагааны турш	MNS 5626:2006 Цацрагийн хамгаалалт. Лабораторийн гамма спектрометрийн арга
Усан орчин									
16	Төслийн үйл ажиллагааны БОМТ-ын хүрээнд 5жилд 0.929 л ус ашиглана.	Ашиглах усны хэмжээгээр ус ашиглах гэрээ байгуулан, ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг жил бүр гаргуулан ажиллах.	Төслийн талбай	-	Удаа	ҮАЗ		Жил бүр	Усны тухай хуулийн 28, 29, 30-р зүйл
17		Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан ашиглах хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх, усыг үр ашигтай, хэмнэлттэй ашиглах	Төслийн талбай	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
18		Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах, шугам хоолой бүрийн тоолуурын баталгаажуулалт, түүний хяналтыг хийх	Төслийн талбайн уст цэг	4	ш	0.07	0.28	Эхний жил	Усны тухай хуулийн 30.1.4-р зүйл
19		Усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах.	Төслийн ажилчид	5	Удаа	0.5	0.5	Жилд 1 удаа	
20		Ус ашиглалт, хаягдал ус хаях зайлуулсан мэдээллийг усны нэгдсэн мэдээллийн системд бүртгүүлэх	Засагчандмань Майнз ХХК	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	
21	ШТМ зэрэг хор аюул бүхий бодис материалууд	Аадар бороо, шар усны үерийн ус зайлуулах суваг, шуудуу, далангийн технологийн дагуу	Төслийн талбай	-	-	ҮАЗ		Үйл ажиллагааны турш	MNS AASHTO M86:2005



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
	асгарсан тохиолдолд усан орчныг бохирдуулах	мэргэжлийн байгууллагаар хийлгэх							
Биологийн олон янз байдал									
22	Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох	Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх, сургалт, сурталчилгаа хийж байх.	Төслийн ажилчид	1	Нэгж сургалт	0.5	0.5	Жилд 1 удаа	Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
23	Уурхайлалд өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих	Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбайн ойр орчимд	1	Удаа	1.0	1.0	Жилд 1 удаа	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
24		Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байх талаар сургалт ухуулга явуулах	Төслийн ажилчид	1	Удаа	0.5	0.5	Жилд 1 удаа	
		Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийн ойролцоо анхааруулсан тэмдгүүд байрлуулах	Төслийн талбай болон түүний ойр орчимд	5	ш	0.05	0.25	1, 4 дэх жил	MNS4597:2014.
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал						4,810,000 ₮			

Тайлбар: YA3*- Үйл ажиллагааны зардалд тусгах


4.4 НОГООН БАЙГУУЛАМЖ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Засагчандмань Майнз ХХК-ийн Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаа эхлэхтэй холбоотойгоор 2026 оны 5 сард хаврын мод тарилтын үеэс эхлэн мод тарихаар төлөвлөж төслийн талбайд 2026-2030 онд хийх ногоон байгууламжийн тарилтын төлөвлөгөөг жил бүрээр тооцож доорх хүснэгтэд тусгалаа.

Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Гүйцэтгэх ажил		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, мян.төг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж	Мод	ш	1000	5.0	5.0		
2	Тэрбум мод өрх бүр 5 мод хөтөлбөр	Мод	ш	200	1.0	1.0		
3	Тэрбум мод Дэлгэрэх сум	Мод	ш	3000	5.0	15.0		
4	Тариалах талбайг бэлдэх	Бордоо ашиглан хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх	кг	100	30.0	0.6	2026 оны хавар эсвэл намрын улиралд тариалах	Мод тарих гарын авлага
5	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, тордлогоо хийх	Мод, ургамлыг услах, нөхөн тарилт хийх.	-	-	-	ҮАЗ		
Нийт						21.6		

Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд 21,600,000 ₮ төгрөг зарцуулахаар байна.



Зураг 4-1. Ногоон байгууламжийн төлөвлөлтийн зураг



4.5 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Засагчандмань Майнз ХХК нь 2026 онд Дэлгэрэх сумын бэлчээрийг сайжруулах, эвдэрч орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- Энэ хүрээнд орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран сумын бэлчээр, доройтсон газрыг нөхөн сэргээх, техникээр хангах арга хэмжээг зохион байгуулах юм.
- Могойны нарийвчилсан судалгаа хийж зүйлийн бүрдэл, тоо толгой, нягтшилыг үнэлж хортой, болон хоргүй могойг хэрхэн таних талаар уурхайн ажилчид, нутгийн малчид, ЕБС -ийн сурагчдад танин мэдэхүйн мэдээлэл олгох ажлыг зохион байгуулна.
- Мөн Дэлгэрэх сумын хэмжээнд мэргэжлийн байгууллагаар идлэг шонхрын нарийвчилсан судалгааг эхний жилийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- Усны нөөцийн хамгаалалт болох бороо, цасны усыг хуримтлуулах бичил нуур байгуулах ажлыг эхлүүлэх, эхний ээлжид бичил нуур байгуулж болохуйц боломжит газрыг тогтоох зэрэг судалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.

Эдгээр үйл ажиллагаанд нийт 60.88 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд 2026 онд дээрх арга хэмжээг Дэлгэрэх сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

4.6 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Засагчандмань Майнз ХХК-ны Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг дэвсгэрт хэрэгжих Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн талбайн нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

4.7 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг дахь Засагчандмань Майнз ХХК-ийн Чандмань Хар уул ашиглалтын талбайд хүрэл зэвсгийн үед холбогдох булш оршуулгын дурсгал 39, хүннү булш 11, монголын үеийн булш 45, он цаг тодорхойгүй булш 14, чулуун байгууламж 16, тахилын байгууламж 5 тус тус нийт 130 дурсгал олдсон ба авран хамгаалах малтлага хийсэн (Ч.Амартүвшин нар, 2012).

Зөвшөөрлийн талбайд биет болон биет бус соёлын өв, уламжлалт хэрэглээ, зан үйлтэй холбоотой газар, объект олдоогүй байж болзошгүй тул төслийн нийгэм, соёлын эрсдэлийг бууруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөх зорилгоор угсаатан зүйн урьдчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхийг зөвлөж байна. Судалгааны хүрээнд тухайн талбайд соёлын болон түүхэн ач холбогдол бүхий объект, археологийн шинж тэмдэг байгаа эсэхийг тогтоох, уламжлалт хэрэглээ, нутгийн иргэдийн соёлын практиктай холбоотой ач холбогдлыг үнэлэх, шаардлагатай тохиолдолд хамгаалалтын бүс тогтоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргана. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн төслийн төлөвлөлт, олборлолтын хил хязгаар, инженерийн шийдэлд шаардлагатай зохицуулалт хийх эсэхийг шийдвэрлэх бөгөөд энэхүү арга хэмжээ нь орон нутгийн оролцоог хангах, соёлын өвийн хамгаалалтын шаардлагыг биелүүлэх, төслийн нийгмийн эрсдэлийг бууруулахад чиглэнэ.

Соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхайн ашиглалтын явцад соёлын өв илэрсэн тохиолдолд уурхай үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4.8 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Засагчандмань Майнз ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны



Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн
ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллахаар 2026 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 9,170,000 ₮ зарцуулахаар төлөвлөв.



Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн
ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Нийт зардал, сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагуулах	Засагчандмань Майнз	Нэгж сургалт	5	2.0	2.0	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Гамшгаас хамгаалах тухай хууль
2	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж төслийн талбайд байршуулах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Төслийн талбай	ш	2 ш галын сараа 15 ш галын хор	1.4 0.07	3.85	Үйл ажиллагааны турш	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS5566:2020.
3	Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект бүрд онцлогийг тусган тавих	Төслийн талбай	ш	5 ш самбар	Галын самбар 0.02	0.02	Үйл ажиллагааны турш	
4	Хор аюултай бодис хадгалах, ашиглах үед химийн бодис асгарсан, алдагдсан, гал түймэр гарснаас үүсэж болзошгүй аюул, ослын үед ажиллах дүрэм журмыг боловсруулан, жил бүр ажилчдад таниулан, дагаж мөрдөх	Засагчандмань Майнз	Нэгж сургалт	5 удаа	10 хүн= 0.15	1.5	Жилд 1 удаа	MNS4244:2026
5	Шатах тослох материал асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, саармагжуулах асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах (элс, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, хүрз, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болог тууз зэрэг)	Төслийн талбай	иж бүрдэл	4 ш иж бүрдэл	Иж бүрдэл 1.8	1.8	Үйл ажиллагааны турш	
Нийт						9.17		



4.9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Засагчандмань Майнз ХХК-ийн 2026 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд нийт 11 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. 2026 оны Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг Хүснэгт 4-5-д тусгав.



Хүснэгт 4-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8	9
1.		Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг төслийн талбайд байршуулах	Төслийн талбай	1	ш	5.0	5.0	Эхний жил	
		Ахуйн хатуу хог хаягдлын ангилан ялгах цэг байгуулах	Төслийн талбай	1	ш	5.0	5.0	Эхний жил	
2.		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хог хаягдал дахин боловсруулах төсөл хөтөлбөр, үйлдвэрт нийлүүлэх	Төслийн талбай			ҮАЗ		Жилд 1-2 удаа	
3.	Энгийн хог хаягдал	Бусад хог хаягдлыг гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	60	удаа	0.02	0.24	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
		Ангилан ялгаж буй хог хаягдлаа гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	10	-	0.05	0.6	Сард 1 удаа	
		Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх	Төслийн талбай			ҮАЗ		Жилд 1-2 удаа	
		Энгийн хог хаягдлын нийт зардал					10.84		
4.	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, төслийн талбайд зориулалтын савыг байрлуулан, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбай	1	ш	5.0	5.0	Эхний жил	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
		Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах шилжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналтыг тавьж, бүртгэл хөтлөх	Засагчандмань Майнз ХХК	-	-	ҮАЗ		Сард 1 удаа	



Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн
ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он


№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрд сургах.	Аюултай хог хаягдалтай харьцах ажилчид	-	Нэгж сургалт	1.0	1.0	Жилд 1 удаа	
		Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах	Төслийн талбай	-	кг	ҮАЗ		Жилд 4 удаа	
		<i>Аюултай хог хаягдлын нийт зардал</i>				<i>6.0</i>			
		Нийт зардал					16,840,000 ₮		

4.10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний чухал хэсэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1.5-т зааснаар Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Засагчандмань Майнз ХХК бүрэн хариуцна.



Зураг 4-2. Орчны хяналт шинжилгээний цэгүүд



Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	
Агаарын чанар							
1.	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаарын температур, чийг 	Баяжуулах үйлдвэр баруун тал Баяжуулах үйлдвэр зүүн тал Хаягдлын овоолгын салхин доор Кемпийн урд Засварын цехийн урд Ухашаас 200м урд Ухашаас 700м урд Дэлгэрэх сумын зүгт	8	Сард 1 удаа	Хэмжилтийн багаж худалдан авч хэмжилтийг хийх: Багажийн үнэ 10 сая	10.0	MNS.4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS ISO4227-2002 Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө
2.	<ul style="list-style-type: none"> Дуу чимээ 	Баяжуулах үйлдвэр баруун тал Баяжуулах үйлдвэр зүүн тал Ухашын хажууд Кемпийн урд Засварын цехийн урд Постын хажууд	6	7 хоногт 1 удаа	Хэмжилтийн багаж худалдан авч хэмжилтийг хийх: Багажийн үнэ 1 сая	1.0	MNS4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаарын чанар (хөндлөнгийн хяналт)							
3.	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаар бохирдуулагч хий (SO₂, NO₂) Дуу чимээ 	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	8	Жилд 1 удаа	1 дээж 100,000*8 Жилд 800,000		MNS.3384:1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Хөрсөн бүрхэвч							
4.	<ul style="list-style-type: none"> Хөрсний хими болон физикийн ерөнхий шинжилгээ Хүнд металл 	Баяжуулах үйлдвэрийн хажууд Хаягдлын сангийн хажууд Кемпийн урд Кемпийн хогийн цэгийн хажууд Засварын цех Ухашын хажууд Хөрсний овоолгын хажууд Постын хажууд Хяналтын цэг	9	Улиралд 1 удаа	35,000	1 дээж 35,000*9*4 Жилд 1,260,000	MNS.2305:1995. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх
Хөрсөн бүрхэвч (хөндлөнгийн хяналт)							
5.	<ul style="list-style-type: none"> Хөрсний хими болон физик Хүнд металл 	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	9	Жилд 1 удаа 5 жилд	35,000	1 дээж 35,000*9 Жилд 315,000	MNS.2305:1995. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх
Усан орчин							
	<ul style="list-style-type: none"> Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Хүнд металлын шинжилгээ (Унд ахуйн худгийн усанд микробиологийн шинжилгээг хийлгэх) 	Уурхайн голын хойно болон урд Кемпийн ундны ус Худаг 1 Худаг 2 Худаг 3 Худаг 4	9	Улиралд 1 удаа	54,000	1 дээж 54,000*7*4 Жилд 1,512,000	MNS.5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усан орчин (хөндлөнгийн хяналт)							
6.	<ul style="list-style-type: none"> Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Хүнд металлын шинжилгээ 	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	7	Жилд 1 удаа 5 жил		1 дээж 54,000*7 Жилд 378,000	MNS.6230:2010. Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага



Чандмань Уулын төмөр (зэс, алт)-ийн хүдрийн
ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2026 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	<ul style="list-style-type: none"> (Унд ахуйн худгийн усанд микробиологийн шинжилгээг хийлгэх) 						
Биологийн олон янз байдал (хөндлөнгийн хяналт)							
7.	<ul style="list-style-type: none"> Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц 	Тэсрэх материал агуулах хажууд Хөрсний овоолго урд Кемпийн ойролцоо Баяжуулах үйлдвэрийн ойролцоо Ухашийн хажууд Хяналтын цэг-1 Хяналтын цэг-2	7	Жилд 1 удаа		2.0	Батлагдсан арга зүйн дагуу
	<ul style="list-style-type: none"> Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг Амьтдын тоо толгой 	Төслийн талбай болон түүний ойролцоох уст цэг, мод бутлаг ургамал бүхий талбайд	5	Жилд 1 удаа		3.0	
Нийт зардал					20,265,000 ₮		

Тайлбар: УАЗ*- Үйл ажиллагааны зардалд тусгах

4.11 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Засагчандмань Майнз ХХК-ийн 2026 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд нийт 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. 2025 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг Хүснэгт 4-7-д тусгав.

Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2026 он			
			V	VIII	XII	
1	2	3	4	5	6	
1.	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	0.5		+		Удирдлага, БОМ, ХАБЭА
2.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	1.0	+			БОМ
3.	Шаардлагатай үед хэрэглэх иж бүрэн эмийн санг заавартай нь байрлуулах, тогтмол хугацаанд нөхөн сэлбэх	1.0			+	ХАБЭА
4.	Байгаль орчныг хамгаалах болон нийгмийн хамгааллын боловсруулсан бодлого, чиглэлээр дотоод журмыг мөрдөж ажиллах, мөн тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ болон байгууллагын батлагдсан журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах.	0.5		+		Удирдлага, БОМ
5.	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	15			+	Удирдлага, БОМ
Нийт зардал			18,000,000 ₮			

Тайлбар: УАЗ* - Үйл ажиллагааны зардалд тусгах

4.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. БОМТ-г боловсруулж, Дорноговь аймгийн БОАЖГ-т батлуулахаар хүргүүлж, батлагдсаны дараа тухайн жилийн БОМТ-г ханган биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор харьяалагдах аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

Стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг тухайн байгууллагаас БОАЖГ-т гаргасан хүсэлтэд 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байгаа тухай тодорхойлон ирүүлсний дагуу тухайн оны 3 дугаар улиралд багтаан газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргана.

Орон нутгийн байгаль орчны газраас тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянасны дараа хяналтын хуудсыг гаргаж өгөх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү хуудсыг тухайн оны БОМТ-ний биелэлтийн тайланд хавсарган өгнө.

Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын 1-р багийн ИНХ	БОМТ-ний хүрээнд гүйцэтгэсэн ажлын хураангуй	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн хураангуй танилцуулга	Тухайн жилд			1-р баг
2	Дэлгэрэх сумын ЗДТГ			Тухайн жилд			Дэлгэрэх сум
3	Дорноговь аймгийн байгаль орчны газар		Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг дэлгэрэнгүй илэрхийлсэн байна. Ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	11-р сарын 01-ээс өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгав.	Байгаль орчны хэлтэс	Дорноговь аймаг
4	БОУАӨЯ	Тайлангийн эх хувь албан бичгийн хамт		12-р сарын 30-аас өмнө			Улаанбаатар хот

Засагчандмань Майнз ХХК нь жил бүр БОМТ боловсруулан БОАЖЯ-аар батлуулж, БОМТ-нд тусгагдсан ажлуудыг ханган биелүүлж, БОМТ-ний биелэлтийн тайланг жил бүр Дорноговь аймгийн БОАЖГ-т хүргүүлэх үүрэгтэй.